

## ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

### EXECUTION OF THE PENALTY FOR LIMITATION OF FREE TRAVEL RIGHT AND WAYS TO IMPROVE IT



**Б.Байгальмаа**

*Өмнөговь аймаг дахь*

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын  
техник хяналтын ажилтан, дэслэгч*

**Товч утга:** Дэлхийн улс орнуудын хууль, эрх зүйн хөгжил нь нийгмийн хөгжлийнхөө үйл явцтай зэрэгцэн шинэчлэгдэж боловсронгуй болсоор байгаагийн тод жишээ нь технологийн дэвшлийг ашиглан цахим төхөөрөмжийг гэм буруутай хүний биед зүүж байршлыг тогтоон, зорчих маршрутыг хязгаарлан, хяналт тавьдаг болсон.

Монгол улсад шүүхээс ял шийтгэгдсэн этгээдийн зорчих хөдөлгөөнд хяналт тавих зарчмаар ашигладаг цахим тоног төхөөрөмжийг ял эдлүүлэх ажиллагаанд 2021 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд, боловсронгуй болгох үйл явц явагдсаар байна.

Манай улс гэмт хэрэг үйлдсэн хүний хөл, гарын аль нэгэнд **бугуйн цаг** зүүхээд гэр бүлтэйгээ хамт байж, нийгмийн харилцаанд хэвийн оролцож хийсэн хэргийнхээ ялыг үүрээд явна гэж хэн ч төсөөлж байгаагүй биз. Энэ нь “Зорчих эрхийг хязгаарлах ял” юм. Илтгэлд уг ялын хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар бичлээ.

Дэлхийн улс орнуудад цахим бугуйвчийг анх Америкийн Нэгдсэн Улсад 1983 оноос хэрэглэж эхэлсэн ба Англи улс 1989 онд анх нэвтрүүлж, түүнээс хойш Швед, Голланд, Франц, Бельги, Канад, Австри, Швейцар, Герман, Португали, Итали, Израйл, Эстони, Оросын Холбооны Улс 2009 онд, Ази тивд Бүгд Найрамдах Солонгос, Турк, Сингапур зэрэг улсууд 2007 оноос хэрэглэх болсон. Мөн Их Британи, Умард Ирландын нэгдсэн Вант улс, Швед, Нидерланд, Норвег гэх мэт Европын холбооны улсууд 3-12 сарын хугацаатай, БНСУ, Турк гэх мэт Азийн орнууд 3 сараас 30 жилийн хугацаагаар ялыг оногдуулж, хяналт тавьж

ажилладаг байна. Өнөөдөр дэлхийн 30 гаруй оронд цахим бугуйвч хэрэглэгдэж байна.<sup>108</sup>

**Түлхүүр үгс:** Ял шийтгэл, эрүүгийн хариуцлага, эрх үүрэг, гэмт хэрэг, цахим бугуйвч, хязгаарлах бүс, бүс тогтоох, эрх хязгаарлах ял.

**Abstract:** Abstract: A clear example of how the law and legal development of countries around the world continues to be renewed and refined along with the process of social development is the use of technological advances to determine the location, limit and monitor the route of a guilty person by wearing electronic devices.

In Mongolia, the electronic equipment used by the court to monitor the movement of convicted persons has been used in the process of serving sentences since 2021, and the process of improvement is still ongoing.

No one in our country could have imagined that a person who has committed a crime will wear a wrist watch on one of his feet or hands, and then he will be with his family and take part in normal social relations. This is a "penalty to restrict the right to travel". In the report, he wrote about the implementation of the sentence and the problems.

**Keywords:** Punishment, criminal liability, rights and obligations, criminal, electronic bracelet, penalty of restriction of rights.

Эрүүгийн хуульд зорчих эрх хязгаарлах ялыг “Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.” гэж заасан.

Манай улсын хууль тогтоомж, бодлого боловсруулагчид энэхүү ялыг улсынхаа хөрсөнд буулгах гэж 2015 онд Эрүүгийн хуульд ялын бодлогыг тусгаж, 2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хэрэгжих арга замыг батлуулж, хэрэгжилтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр тус тус заасан.

Монгол улсад зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжүүлж эхэлсэн 2021 онд 1713 хүн шийтгэгдэж, шүүхээс шинээр хүлээн авснаас ялын хугацаа дууссан 199, өршөөл уучлал үзүүлсэн 21, хэрэгсэхгүй буюу хүчингүй болгосон 3, нас барсан 8, ял эдэлж байгаа 1194, зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар сольсон 169 гэх тоон үзүүлэлт гарсан байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

---

<sup>108</sup> Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны 2022 онд “Техник хяналтын ажилтан”-уудад зохион байгуулсан сургалт

2023 оны 02 сарын байдлаар 1437 хүн зорчих эрх хязгаарлах ялаар шийтгэгдэж газар, ялын хугацаа дууссан 93, өршөөл уучлал үзүүлсэн 24, хэрэгсэхгүй буюу хүчингүй болгосон 17, нас барсан 27, зорчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар сольсон 735 ялтан байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэгдсэн этгээдийн судалгааг сүүлийн 2 жилийн байдлаар харьцуулбал:

Монгол улсын их хурлаас 2021 оны 07 дугаар 02-ны өдөр баталсан Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон корона вируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, ялын төрлийг солихтой холбогдсон харилцааг зохицуулсан “Өршөөл үзүүлэх тухай хууль” хэрэгжсэнтэй холбоотойгоор хорих ангиас хорих ялаар шийтгэгдсэн хоригдогчийг өршөөлд хамруулж үлдсэн ялыг зорчих эрх хязгаарлах ялаар сольсон байна.

Зорчих эрх хязгаарлах ялын 2023 оны 02 дугаар сарын байдлаарх хэрэгжилтийг графикаар үзүүлбэл:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасны дагуу зорчих эрх хязгаарлах ялыг дараах үндэслэлээр хорих ялаар сольдог. Үүнд:

Хяналтын тоног, төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, хэвийн ажиллагааг сарниулсан;

Зөрчлийн тухай хуульд заасан нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил үйлдэж, шийтгүүлсэн;

Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

Эдгээр зөрчлүүдийг 2-3 удаа давтан гаргасан тохиолдолд ялыг хорих ялаар солино. Мөн хуулийн 170 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараах тохиолдолд ял эдлэх журмыг ноцтой зөрчсөнд тооцох бөгөөд хорих ялаар шууд сольж байна. Үүнд:

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;

Шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;

Техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн;

2021 оны байдлаар зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдэн ял эдэлж байх явцдаа дээрх зөрчлүүдийг гаргасан 169 ялтны үлдсэн хугацааг хорих ялаар сольсон байна. Тухайлбал:

-Зөвшөөрөгдсөн бүсээс удаа дараа гарсан 109 ялтан,  
-Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг 24 цагаас илүү хугацаагаар сарниулсан 41 ялтан,

-Дахин гэмт хэрэг үйлдсэн 19 ялтан байна.

2022 оны 09 дүгээр сарын байдлаар зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдсэн ялтнуудын хорих ялаар сольж буй 186 ялтнаас

-Зөвшөөрөгдсөн бүсээс гарсан 130

-Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг 24 цагаас илүү хугацаагаар сарниулсан 30

-Дахин гэмт хэрэг үйлдсэн 26 ялтан хорих ялаар сольсон байна.

Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг санаатайгаар сарниулна гэдэг нь цахим бугуйвчийг унтраах, эвдэх, оосрыг таслах зэрэг зөрчлүүд орно.

Уг зөрчлүүдийг эхний удаа гаргасан тохиолдолд ялтанд сануулж, техник тоног төхөөрөмжийг 24 цагаас илүү хугацаагаар ажиллагааг санаатайгаар сарниулсан тохиолдолд ахлах шийдвэр гүйцэтгэгч санал гарган прокурорт хянуулан, прокурорын дүгнэлтээр шүүхээс хорих ялаар солино.

2021 он буюу 2022 онд хорих ялаар сольсон үндэслэлийг графикаар харьцуулбал:

Үүнээс үзвэл 2023 оны 02 дугаар сарын байдлаар зорчих эрх хязгаарлах ял шийтгэгдсэн ялтан зөвшөөрөгдсөн бүсээс гарах, дахин гэмт хэрэг үйлдэх зөрчлүүд өмнөх оноос нэмэгдсэн байгаа нь ажиглагдаж байна.

Зорчих эрх хязгаарлах ял нь хүний зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн байдал, нийгэмд учруулсан хор уршгийг харгалзан нийгэм, хамт олныхоо дунд ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох, гэр бүл үр хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ял эдэлж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 167-176 дугаар зүйлд дээрх ялыг хэрэгжүүлэх аргыг тусгаж, үүнтэй уялдуулан гаргасан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь Нийслэл болон орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ажиллаж буй эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, Улсын хэмжээнд ялын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Харин шийдвэр гүйцэтгэгч нар зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, техникийн зааварчилгаа өгөхөөс гадна хувийн баталгаа гаргуулан авч, цахим бугуйвчийн нөөц цэнэг хураагуур, цэнэглэх залгууруудыг хүлээлгэн өгч, хяналтын цахим программд бүртгэж, үүний дараа шүүхийн шийдвэрт заасны дагуу зөвшөөрсөн, хориглосон бүс, явах чиглэлийг

тогтоож, шийдвэр гүйцэтгэгч нар биечилсэн хяналтыг тавихаас гадна “Цахим хяналт, удирдлагын төв”-өөс 24 цагаар давхар хяналт тавьж ажиллаж байна.

Шүүхээс оногдуулсан хязгаарлалтын дагуу хориглосон болон зөвшөөрсөн бүс, замын чиглэлийг тогтоон өгч, тухайн ялтанд аюулгүй ажиллагааны болон ашиглалтын талаар тайлбар, танилцуулга, зааварчилгааг өгдөг бөгөөд хэрэв заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчих, цахим бугуйвчийг таслах, гэмтээх зэрэг зөрчлийг гаргавал сануулга өгөх, гаргасан зөрчлөө дахин давтан гаргах, хориглолт хязгаарлалтыг ноцтой зөрчсөн тохиолдолд зөрчих эрх хязгаарлах ялыг хорих ялаар солихоор хуульчилж өгсөн.

Мөн ялтан нь тогтоосон бүсээс гарч, 24 цагаас дээш хугацаагаар цахим бугуйвчийг цэнэглэхгүй, гар утсаар холбогдох боломжгүй үед техник хяналтын ажилтан, шийдвэр гүйцэтгэгчийн хамт эрэн сурвалжлах ажиллагааг зохион байгуулж олсон даруйд Прокурорын байгууллагад хорих ялаар солих саналыг материалын хамт хүргүүлэн ажиллаж байна. Гэвч Прокурорын байгууллагаас материалтай танилцаж, хянаж шүүхийн байгууллагад хүргүүлэх, шүүхээс шийдвэр гарах хүртэлх хугацаанд тухайн ялтныг дахин ялаас оргон зайлах нөхцөл бүрдэж байгаа гэж үзэж тулгамдсан дараагийн асуудлаар авч үзэж байна.

### Дүгнэлт:

Илтгэлийн хүрээнд Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг боловсронгуй болгох талаар дараах дүгнэлтийг хийлээ.

Энэхүү ял хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны 07 дугаар сард гарсан Өршөөлийн хуультай холбогдуулан суллагдсан нэлээдгүй хоригдогчдын хорих ялыг дээрх ялаар сольж хэрэгжилт, ач холбогдлыг мэдрэх боломж олдсон гэж үзэж болно.

Зорчих эрх хязгаарлах ялыг хэрэгжилт нь аймаг, сум дүүргийн төв суурин газар болон алслагдмал зэлүүд багт амьдардаг гэмт хэрэг үйлдсэн иргэдэд харилцан адилгүй үйлчилж байна. Жишээ нь зорчих эрх хязгаарлах ялын тоног төхөөрөмж байнгын асаалттай байх мөн тухайн тоног төхөөрөмжийг хянах дата сүлжээтэй байснаар ял эдлүүлэх нөхцөл бүрдэж байгаа нь ямар нэгэн дата сүлжээгүй тог цахилгаангүй газрын хөнгөн, хүндэвтэр, анх удаа гэмт хэрэг үйлдсэн иргэнийг сонгох санкц бүхий зүйл эрүүгийн хуулийн зүйл заалтаас сонголтгүй болгож байгаа нь хүний эрх, ялын бодлогыг алдагдуулах ялтны эрх зүйн байдлыг дордуулж байгаа нь зорчих эрх хязгаарлах ялын хяналтын тоног төхөөрөмжийг боловсронгуй болгохыг шаардаж байна.

Хорихоос өөр төрлийн ялын нэг төрөл болох зорчих эрх хязгаарлах ял нь иргэдэд Монгол улсын үндсэн хуулиар олгосон иргэний язгуур эрх ашгийг дээдэлж, энэрэнгүй, эрүүл мэнд, эрх чөлөө, сурч боловсрох, гэр бүлтэйгээ байж үр хүүхдээ тэжээн тэтгэх, зэрэг эрхийг дээдэлж, ял эдлүүлэх ажиллагаа явагдаж

байгаа учир зорчих эрх хязгаарлах ялтан үүргээ биелүүлээгүй бол хүлээх хариуцлагыг хурдан шуурхай авах шаардлагатай бөгөөд ял завшуулахгүй байх бодитоор ял эдлүүлэх нь чухал гэх асуудал алба хаагчдад тулгарч байна.

Тухайлбал оргосон ялтан этгээдийг эрэн хайх нэгжийг бүсчлэн байгуулж, түүний шаардлагад нийцсэн алба хаагчийг бий болгох тусгай хэрэгсэл болон аюулгүй байдлыг бүрэн хангах тоног төхөөрөмжөөр хангах шаардлага үүссэн.

### **Санал:**

Шинэ тутам хэрэгжиж байгаа, амьдралд суурь нь тавигдаж, орчиндоо дасах хугацаа хэдий хэрэгтэй ч цаана нь хүний эрх, гэр бүлийн гишүүдийн эрх ашиг хөндөгдөж байдаг гэдгийг ямагт санаж байх хэрэгтэй. Тиймээс асуудлыг зөв тодорхойлж, хурдан хугацаанд шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байх нь чухал.

Мөн хэрэгжиж эхлээд 2 жилийн нүүрийг үзэж зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилтийн талаарх саналаа өөрийн өнцгөөс бичихийг хичээлээ. Үүнд:

1. Оргосон ялтныг эрэн сурвалжлах ажиллагааны зардал батлагдаагүй тул зардлын нормативыг батлах, эрэн сурвалжлах ажилтантай болох

2. Аймаг нийслэлээс алслагдсан сумдын ялтнуудыг холбогдох хуульд зааснаар цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах талаар тусгаж өгсөн ч төдийлөн үр дүнгүй байгаа тул сумын хэсгийн төлөөлөгчийн чиг үүрэг буюу гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэмж тусгуулах, энэ нь ажлын хариуцлагыг нэмэгдүүлнэ.

3. Оргосон ялтны ял солих санал хүргүүлснээс хойш шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд тухайн ялтныг хаана байлгах, хэрхэн хяналт тавих талаар хуульд заалт оруулах. Ямар нэгэн шүүгчийн захирамж гараагүй байхад Цагдан хорих байранд хорьж болохгүй, явуулчихлаа гэхэд дахин алга болж, дахиад л эрэн сурвалжлах хүн хүч, шатахуун гээд зардал гарна. Эсвэл нэг шинэ цахим бугуйвч зүүлгээд явуулчихлаа гэхэд дахиад эвдэх, алга болгох эрсдэл байна. Иймд оргосон ялтныг эрэн хайж олсноос хойших шүүх шийдвэрлэх хүртэлх хугацаанд ахлах шийдвэр гүйцэтгэгчийн тогтоолоор цагдан хорьж, саатуулах зохицуулалттай байвал ялтныг дахин оргох гэмт хэргээс урьдчилан сэргийлж, хорих ялаар солих үйл ажиллагааг явагдах хугацаанд хүндрэл учрахгүй гэж бодож байна.

Цаашид зорчих эрх хязгаарлах ял улам илүү өргөжиж, цахим бугуйвч болон техник хэрэгсэл илүү хөгжил дэвшилттэй, мөн хяналтын үйл явц хариуцлагатай, чанартай хэрэгжинэ гэдэгт би итгэлтэй байна.

### **Ашигласан эх сурвалжийн жагсаалт:**

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/
2. Эрүүгийн хууль /2015 он/

3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны мэдээ, тайлан 2022 оны 09 сарын байдлаар
4. Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад ашиглагдах гарын авлага /2021 он/
5. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийн эмхэтгэл /2022 он/

---o0o---